



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 8/2

Улаанбаатар хот

Гишүүнчлэлийн жилийн хөлс хөнгөлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, Гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржийн 2022 оны үнэт цаасны арилжааны нийт үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх гүйлгээг дангаар хийсэн Монголын хөрөнгийн биржийн гишүүн “хавсралт-1”-д нэр дурдсан 7 үнэт цаасны компанид 2023 оны гишүүнчлэлийн жилийн хөлснөөс тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлсүгэй.
2. Монголын хөрөнгийн биржийн 2023 оны гишүүнчлэлийн жилийн хөлсийг хөнгөлсөн дүнгээр тооцож нэхэмжлэхийг Санхүүгийн алба /Х.Эрдэнэбүрэн/-нд даалгасугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавих, гишүүн компаниудад мэдэгдэх ажлыг Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1523030001

Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын
06-ны өдрийн тоот тушаалын хавсралт



Д/д	Код	Гишүүн ҮЦК-ийн нэрс	Арилжааны үнийн дүн	Эзлэх хувь
1	GLMT	"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК" ХХК	270,116,618,525.29	23.3%
2	BDSC	"БИ ДИ СЕК ҮЦК" ХХК	207,759,646,914.68	17.9%
3	INVC	"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК	166,159,986,217.40	14.3%
4	ARD	"ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК	151,896,191,250.05	13.1%
5	MIBG	"МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК" ХХК	106,510,290,864.97	9.2%
6	MNET	"АРД СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХХК	65,612,358,042.62	5.7%
7	TTOL	"АПЕКС КАПИТАЛ ҮЦК" ХХК	62,468,615,500.13	5.4%